

ШУТИС-ИЙН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ СУРАЛЦАГЧ ОЮУТНУУДЫН ОНЦЛОГТ ТОХИРОХ СУРГАЛТЫН ОРЧИН БҮРДҮҮЛЭХ НЬ

С. Ариунцэцэг
Докторант

Шинжлэх ухаан, технологийн их сургууль
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль

ariuntsetseg_s@must.edu.mn

***Хураангуй:** Дэлхий нийтийн боловсролын чиг хандлага нь хөгжлийн бэрхшээл, ядуурал, хүйсийн ялгаа, яс үндэс, шашин шүтлэг зэргээс шалтгаалан нийгмийн үйлчилгээний гадна үлдэж болзошгүй суралцагч хүүхэд, оюутан залуучуудыг бусдын адил чанартай боловсрол эзэмших эрхийг хамгаалсан тэгш хамруулан сургах тогтолцоонд чиглэж байна Тогтвортой хөгжлийн зорилт 4, Боловсрол 2030 хөтөлбөрт тухайн асуудлаар бодлогын баримт бичигт” Иргэдийн насан туршид суралцах хэрэгцээ, суралцагчийн сонирхол, авьяас, чадвар, хөгжлийн онцлогт нийцсэн, тэдэнд тэгш боломж олгосон, олон хувилбартай, чөлөөтэй, нээлттэй байх” зорилтыг дэвшүүлсэн.*

***Түлхүүр үгс:** Тусгай хэрэгцээт суралцагч оюутан*

УДИРТГАЛ

Тусгай хэрэгцээт боловсрол нь боловсролын бүрэлдэхүүн хэсэг учраас боловсролын ихэнх түгээмэл ухагдахуун, нэр томъёог хэрэглэдэг. Үүний зэрэгцээ тусгай боловсрол нь эрдэм шинжилгээ, судалгааны өвөрмөц онцлогоо тусгасан өөрийн ухагдахуун, онцлог нэр томъёотой. Тухайлбал тусгай боловсрол хэнд хамаарч байгааг тодорхойлсон багц ухагдахуун; тусгай боловсролын зорилго, зорилт, зарчим, арга хэрэгсэл, тусгай хэрэгцээт боловсрол эзэмших үйл явцын зохион байгуулалт, тусгай боловсролын технологийн тогтолцоо зэрэгтэй холбоотой

ухагдахууныг ч тайлбарласан байдаг.

МУ-ын УИХ-ын 2015 оны Төрөөс боловсролын талаарх баримтлах бодлого (2012-2024 он) батлах тухай 12-р тогтоолд 2.1.8” Иргэдийн насан туршид суралцах хэрэгцээ, суралцагчийн сонирхол, авьяас, чадвар, хөгжлийн онцлогт нийцсэн, тэдэнд тэгш боломж олгосон, олон хувилбартай, чөлөөтэй, нээлттэй байх” зорилтыг дэвшүүлсэн. Мөн Тогтвортой хөгжлийн зорилт 4, Боловсрол 2030 хөтөлбөрт тухайн асуудлаар бодлогын баримт бичигт тусгах, уялдуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаа эхлүүлээд явж байгаа нь энэхүү ШУТИС-ийн чанарын зорилготой мөн уялдаж байна.

2022-2023 оны хичээлийн жилд Монгол улсын хэмжээнд

- Сургуулийн өмнөх боловсролд 1439
- Ерөнхий боловсролд 6258
- Мэргэжлийн боловсрол сургалтын байгуулгад 777
- Дээд боловсролд 333 суралцагч суралцаж байна.

Эдгээр хүүхдийн 12 хувь нь харааны, 7.8 хувь нь хэл ярианы, 7.7 хувь нь сонсголын, 18.2 хувь нь сэтгэцийн бэрхшээлтэй, 22.8 хувь нь хөдөлгөөний буюу тулгуур эрхтний, 23.9 хувь нь хавсарсан бэрхшээлтэй гэсэн мэдээлэл байдаг. (БШУЯ, 2022) .

ОНОЛ, АРГА ЗҮЙН ХЭСЭГ

Боловсролын байгууллагын чанарын менежментийн тогтолцоо ISO21001:2018 стандартын 5.1.3-т: “Тусгай хэрэгцээт суралцагчид нь энгийн зааварчилгаа, үнэлгээний арга барилаар хангагдах боломжгүй байж болно. (жишээ нь: зан байдал, харилцааны, оюуны, бие бялдар, авьяас билиг эсвэл нэгээс илүү онцгой авьяастай учир тусгай боловсрол эзэмших шаардлагатай суралцагчид). Энэ нь сонирхогч талууд өөрсдийн үйл ажиллагаандаа хэрэгцээтэй мэдээллийг хүлээн авахын тулд харилцааны сувгуудын оршин тогтнох байдлыг хангахыг шаардах боломжтой гэсэн үг юм.

Дээд удирдлага нь:

• сургалтын орчинд хүртээмжтэй байдлыг хангахын тулд нөөц бололцоо, сургалтаар хангана;

• боловсрол эзэмших тэгш боломжоор хангах, бусад суралцагчдын адил сургалтын орчныг бүрдүүлэхийн тулд тусгай хэрэгцээтэй суралцагчдыг боломжийн орон байраар хангана” (MNS, 2021) гэжээ.

Тиймээс ШУТИС тусгай хэрэгцээт суралцагчид гэж хэн бэ? гэдгээ эхлээд тодорхойлохын тулд мэргэжлийн багш нартай хамтарч ажилласан. Тухайлбал: судалгаа хийх, үнэлэх, гарын авлага гаргах гэх мэт. Ингэж ажилласнаар ШУТИС-ийн сонирхогч тал болох тусгай хэрэгцээт суралцагсад тэр дундаа хөгжлийн бэрхшээлтний оюутнууд өөрт хэрэгцээтэй мэдээллийг хүлээн авах боломжтой болох юм.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын (WHO) эрдэмтэн судлаачид хүний үйл ажиллагааг олон талаас нь судлаж олон салбарын мэргэжлийн хүмүүсийн дунд нэгдсэн чиг ойлголтыг буй болгохын тулд олон улсын “Хөгжлийн бэрхшээлийн ангиллыг гаргасан” (International Classification of Impairment Disability and Handicap) “Impairment” буюу “өвчин согог” гэдэг үгийг бие эрхтэний хүрээнд авч үзэж эрүүл мэндийн салбарт хэрэглэхийг заасан. Харин “Disability” буюу “ чадварын

өөрчлөлт/алдалт” гэх ухагдахууныг суралцагчийн суралцахуйн, танин мэдэхүйн хүрээнд авч үзэж боловсролын салбарт хэрэглэхийг заажээ. “Handicap” буюу “саад бэрхшээл” гэх үгийг хувь хүн болон нийгмээс үүдэлтэй тул нийгмийн салбарт хэрэглэнэ гэж зөвлөжээ. (World Health Organization, 2011)

Хөгжлийн бэрхшээлтэй

гэдэг нь дээрх чадвар сул болон чадваргүйн улмаас хувь хүний үйлдэлд саад учруулж байгаа, хувь хүний үйл хөдлөлийг хязгаарлаж байгаа сул талыг хэлнэ гэжээ.

Монгол улсын Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд: “Бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн согогийн улмаас бусдын адил нийгмийн харилцаанд оролцох чадвар нь бүрэн болон 12 сараас дээш хугацаагаар хязгаарлагдсан хүнийг хөгжлийн бэрхшээлтэй иргэн /ХБИ/ гэж ойлгоно” гэж тус тус заасан байна. (ХНХЯ, Нийгмийн халамжийн тухай хууль, 2008)

Монгол улсын хувьд Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын яамны “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комисс”-ийн 2018 оны судалгаагаар хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад тулгамдаж буй асуудлыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох арга, аргачлал батлагдаагүй
 - Хөгжлийн дэмжлэгт хамрагдаж чадахгүй /сургууль боловсролын үйлчилгээ/
 - Үйлчилгээний хүртээмж барилга, зам, тээвэр, хэвлэл мэдээллийн хүртээмж хангалтгүй
 - Ялгаварлан гадуурхалтад өртдөг
 - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн талаар олон нийтийн ойлголт, мэдлэг дутмаг
 - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучууд хүчирхийлэл, үл хайхрах байдалд өртөх эрсдэл ихтэй
 - Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн гэр бүл, эцэг эхийг дэмжих дэмжлэг хангалтгүй гэж тодорхойлсон байна.
- Хөдөлгөөний бэрхшээлтэй суралцагчдад сурах үйл явцад тулгарах сэтгэл зүйн хүндрэлүүд*
- Бусдаас байнга дэмжлэг авах хүсэл бага
 - Бусдад хүндрэл учруулж буйдаа эмзэглэж санаа зовдог
 - Дотогшоо өөрийн сэтгэл хөдлөлийг нээж ярилцахдаа сайн биш
 - Гэнэт огцом бухимдах, стрест автах
 - Орчны болон орон зай, цаг хугацаа, хөдөлгөөний баримжааны алдагдалтай, хөгжил дутуу
 - Мэдэрч танин мэдэхээс сэтгэж танин мэдэх, үйл

ажиллагаагаараа танин мэдэх, онолын түвшинд танин мэдэхийг бүхэлд нь хамарсан доголдол үүснэ

- Уур бухимдлаа тайлах зөв арга сонгох тал дээр дутмаг

- Тулж харилцах чадвар, хүний сэтгэлийн өнгө аясыг харж мэдрэх, харилцаагаа тухайн нөхцөлд зохицуулах мэдрэмж дутуу, утга санааг илүү тусгадаг учир мэдрэмтгий харьцдаг нийтлэг сул талтай юм.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Боловсролын

байгууллагын чанарын менежментийн тогтолцоо ISO21001:2018 стандартын 7.2.2-т: “Байгууллага нь сурган хүмүүжүүлэгчдийг дэмжих нөөцөөр хангана:

а) тусгай хэрэгцээ шаардлагатай суралцагчидтай ажилладаг сурган хүмүүжүүлэгч, ажилтнуудыг зохих мэргэжлийн сургалтад хамруулах ёстой:

1) өөр өөр шаардлага бүхий суралцагчдын сургалтын хэрэгцээтэй танилцах

2) ялгаатай заавар ба үнэлгээ

3) сургалтын шат

б) мэргэжилтэнтэй холбогдох сүлжээнд нэвтрэх боломжоор хангах

ТАЙЛБАР 1: Мэргэшсэн сургалт нь янз бүрийн шаардлагад нийцсэн

суралцагчдын хэрэгцээг хангахын тулд ялгавартай сургалтад хамруулж болно.

ТАЙЛБАР 2: Мэргэжилтнүүд сэтгэл судлаач, сургах хөгжүүлэх мэргэжилтэн, ярианы эмч нарыг багтааж болно” (MNS, 2021) гэжээ.

Харин боловсролын тухай хуульд: хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн сургалтын төлбөрийн зээл, буцалтгүй тусламж, нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг тусгай хэрэгцээтэй уялдуулан тогтоох, барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, багш ажилтан нь тусгай хэрэгцээнд нийцсэн эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан, бусдын адил тэгш байх нөхцөлийг бүрдүүлэх талаар тусгасан.

ШУТИС-д 2023-2024 оны хичээлийн жилд нийт хөгжлийн бэрхшээлтэй тусгай хэрэгцээт боловсролын дэмжлэг үйлчилгээ авах хэрэгцээтэй 58 оюутан суралцаж байна.

1-р хүснэгт. ШУТИС-д суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын тоо
статистик мэдээлэл

№	Төрөл	Бакалавр		Магистр		Доктор		Бүгд
		эр	эм	эр	эм	эр	эм	
1.	Харааны бэрхшээлтэй	10	3		2			15
2.	Сонсголын бэрхшээлтэй	6	4		1			11
3.	Хөдөлгөөний бэрхшээлтэй	19	5		1	1		26
4.	Ярианы бэрхшээлтэй	3						3
5.	Бусад бэрхшээлтэй	2	1					3
	Нийт	40	13		4	1		58

(Судлаачийн боловсруулснаар)

Дээрх судалгаанаас харахад 91.3% бакалаврын түвшинд суралцаж байгаа бөгөөд тэр дундаа хараа болон тулгуур эрхтний хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын тоо олонх хувийг эзлэж байгаа нь тэдгээрт тохирсон үйлчилгээ дэд бүтэц ямар чухал байгаа нь харагдаж байна.

Тусгай хэрэгцээт боловсролд хамрагдаж буй суралцагчдыг гадны оронд хэрхэн дэмжиж байна вэ?

Японы Боловсрол, Соёл, Спорт, Шинжлэх ухаан Технологийн яамнаас тусгай боловсролыг “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, суралцагчдын хэрэгцээ шаардлагад нийцүүлсэн тэдний бие даасан байдал, нийгмийн оролцоог нь дэмжих, суралцах явцад болон амьдрахад тулгарах саад бэрхшээлийг хөнгөвчлөх, даван туулахад чиглэсэн боловсрол гэж тодорхойлдог.

АНУ 1990 онд Чадварын бэрхшээлтэй хүүхдийн боловсролын хуулийг батлаж тухайн суралцагчийн хөгжлийг үнэлж, тусгай хэрэгцээг илрүүлэх, тодруулах, оношлох, тодорхойлох, ганцаарчилсан хөгжлийн хөтөлбөрүүдийг боловсруулах гэсэн дэд томоохон үйл явцуудыг хамааруулан үзэж хэн, хэзээ, хаана, хэрхэн, яаж үүнийг хэрэгжүүлэх талаар тодорхой зааж өгсөн байна.

АНУ-д тусгай боловсролын үйлчилгээг хүний нөөц, сургалтын орчин болон дэмжлэгийн үйл ажиллагааны багцаас бүрддэг. Энэ нь дэмжлэгийн үйлчилгээ 3 үе шаттай байдаг.

Шатлал 1: Анги бүлгийн зааварчилгаа

Шатлал 2: Зорилтот бүлгийн зааварчилгаа

Шатлал 3: Эрчимжүүлсэн ганцаарчилсан зааварчилгаа

Энэ шаталсан сургалтын багц нь суралцагчдыг сурлагаар

хоцрох, улирах, анги курс алгасах дэвших алдаатай буруу үзэгдлээс урьдчилан сэргийлдэг. Зарим тохиолдолд ердийн анги танхим дахь суралцагчийн хэрэгцээг зөвлөх багш, нарийн мэргэжлийн багшийн туслалцаатайгаар хангаж болдог.

Тусгай хэрэгцээт боловсрол нь уламжлалт болон тусгай боловсролын тогтолцоонд тулгуурлан тэдгээрийг эрүүл мэндийн хязгаарлагдмал боломжтой болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээтэй уялдан хөгжиж байна. Манай улсад оюун санаа биеийн хөгжлийн өөрчлөлттэй залуучуудын дийлэнх нь дээд боловсролд хамрагдаагүй, тэднийг өөртөө татахын тулд тусгай нөхцлийг бүрдүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Гэвч ихэнх их дээд сургуулиуд үүнийг биелүүлж чадаж байна уу? Дээд боловсролын тогтолцоонд тусгай боловсролын хэрэгцээг тодорхойлохын тулд эрх зүй, тогтолцоо, сурган хүмүүжүүлэх арга зүйг судлах шаардлагатай.

ОХУ-д дээд боловсрол эзэмших хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ихэнх нь мэдрэхүйн болон хөдөлгөөний өөрчлөлттэй суралцагсад байдаг. Тэд дээд боловсролын тогтолцооны тусгай боловсролын өнөөгийн байдлыг тодорхойлох, тусгай боловсролын хүчин зүйлүүдийн хөгжил, түүний

хэрэгжилтийн түвшинг судлан шинжилж байна.

Их, дээд сургуульд тусгай хэрэгцээт боловсролыг зохион байгуулахын тулд тохирсон нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай гэж заасан бөгөөд үүнд “сургалт, хүмүүжлийн тусгай хөтөлбөр, арга зүй, тусгай сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн, дидактик хэрэглэгдэхүүн, хамтын болон ганцаарчилсан хэрэглээний сургалтын техник хэрэгсэл ашиглалт, оюутнуудад шаардлагатай техникийн туслалцаа үзүүлэх туслагчийн үйлчилгээ үзүүлэх, бүлгийн болон ганцаарчилсан нөхөн сэргээх хичээл явуулах, боловсролын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын барилга байгууламжид нэвтрэх боломжийг олгох болон эрүүл мэндийн хязгаарлагдмал боломжтой суралцагчдад боловсрол эзэмшихэд боломжгүй юмуу хүндрэлтэй асуудлыг шийдвэрлэх бусад нөхцлийг бий болгох зэрэгт анхаарлаа хандуулж байна.

Томоохон хотуудад ерөнхий боловсролын болон дээд сургуулиуд тусгай хэрэгцээт суралцагсдыг сургах нь материаллаг болон техникийн нөөцийг санхүүжүүлэх, хөгжүүлэхтэй холбоотой юм.

Хөгжлийн бэрхшээлтэй олон оюутнууд их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрийг цаг тухайд нь,

шаардлагатай хэмжээгээр эзэмшиж чадахгүй байна. Тэдэнд өөрсдийнх нь онцлог, чадварт тохирсон хөтөлбөр хэрэгтэй. Дасан зохицсон сургалтын хөтөлбөр, бие даасан сургалтын хөтөлбөр нь эрүүл мэндийн хязгаарлагдмал боломж бүхий болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст амжилттай суралцах чухал нөхцөл юм. Үүний хэрэгцээг ОХУ-ын “Боловсролын тухай” хуульд тусгаж, дээд боловсролын байгууллагуудад хэрэгжүүлж байгаа нь тэгш хамруулан сургах боловсролд шилжихэд хувь нэмэр оруулж, өөр өөр хэрэгцээтэй оюутнуудад сургалтын үргэлжлэх хугацааг уртасган, сургалтын ачаалалыг бууруулж суралцах боломжийг бүрдүүлж байна. Зайны боловсрол, экстернат зэрэг боловсролын хэлбэрүүд нь эдгээр шаардлагыг хангаж, хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад үр дүнтэй байдаг. Эдгээрт бие даан тохирсон хөтөлбөрийн дагуу суралцах, боловсрол эзэмших хугацааг сунгах, сургалтын нэгдсэн хуваарь гаргахгүй байх, оюутнуудын хөдөлгөөний бие бялдрын нөхцлийг бүрдүүлэх шаардлагагүй болно.

Хөгжлийн бэрхшээлтэй суралцагсад хичээлдээ явахын тулд янз бүрийн замыг даван туулахын тулд хүчин чармайлт гаргахаас өөр аргагүй болдог. Тэгвэл эдгээр саад бэрхшээлийг арилгахаар хөгжлийн

бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээнд нийцүүлэн орон зайн болон физик нөхцөлийг өөрчлөхөд туслах зорилгоор “Хүртээмжтэй орчин” хөтөлбөрийг эхлүүлжээ. Бараг бүх боловсролын байгууллагууд тэргэнцэртэй сурагчдад зориулсан налуу зам, цахилгаан шаттай бөгөөд энэ нь брайл үсгээр давхардсан бичээстэй, эрүүл ахуйн шаардлагатай нөхцлийг бүрдүүлсэн байна.

“Хүртээмжтэй орчин” хөтөлбөрийн үйл ажиллагаа нь эрүүл мэндийн хязгаарлагдмал боломжтой болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хүртээмж, тав тухтай байдлыг хангахад нөлөөлж, бие бялдрын хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудыг боловсролын байгууллагад татан оролцуулах, бусадтай адил тэгш эрхтэй, тэдний боловсрол эзэмшихэд хувь нэмэр оруулсан байгааг тэмдэглэн бичих нь зүйтэй.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад дараах дутагдал илэрсэн: олон их дээд сургуулиуд зөвхөн нэг байрандаа, ихэвчлэн үндсэн байрандаа тохиромжтой нөхцөлийг бүрдүүлсэн ч хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөр өөр хичээлийн байранд хичээллэх шаардлага гардаг; зарим боловсролын байгууллагууд нөхцөлийг хараахан тохируулаагүй гэх мэт

боловсролын үйл явцыг зохион байгуулаагүй байна. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй оюутнууд судалгааны ажлын явцад сургуулийн бусад газруудад хүрэх нь ихэвчлэн хэцүү байсан. Тухайлбал: номын сан, судалгааны хүрээлэн, архив, музей.

Үүнээс үзэхэд тусгай боловсролын хэрэгцээтэй оюутнуудыг бэлтгэхийн тулд дээд боловсролын байгууллагууд зохих техникийн тоног төхөөрөмжтэй байх шаардлагатай. Орчин үеийн нөхцөлд боловсролын байгууллагуудын сургалтын үйл явц нь проектор, камер, дуу хураагуур, тоглуулагч, хөгжмийн төв, видео бичигч, телевиз, видео камер, мультимедиа проектор гэх мэт дүрс, дуу, мэдээлэл, харилцаа холбооны техникийн хэрэгсэл, төрөл бүрийн хэрэглүүр бүхий програм хангамжтэй компьютеруудыг ашиглан явагддаг. Боловсролын техникийн хэрэгсэл нь мэдээллийн эх сурвалж болж, харагдах байдлыг нэмэгдүүлэх, оюутнуудын боловсролын хэрэгцээг илүү хангаж, бүх ангиллын оюутнуудад материалыг ашиглах боломжтой болгодог. Арга зүйн болон сургалтын ном зохиолтой ажиллахын тулд цахим нөөцийн хүртээмжтэй сүлжээг зохион байгуулах, цахим номын сан үүсгэх, боловсролын ном бүхий компьютер дээр ажиллах нь материалыг хүлээн авах,

боловсруулах, шаардлагатай их хэмжээний мэдээллийг судлах боломжийг олгодог. Эдгээр техникийн хэрэгслийг ашиглахтай зэрэгцэн их дээд сургуулиуд янз бүрийн хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй суралцагсдыг сургах нөхцлийг бүрдүүлэх тусгай төхөөрөмжийг нэвтрүүлэх хэрэгтэй байна. Жишээ нь: Харааны бэрхшээлтэй оюутнуудын боловсролд сургалтын болон арга зүйн гарын авлагыг том үсгийн хэмжээтэй болон брайл үсгээр гаргах явдал чухал хүчин зүйл болж байна. Мөн их дээд сургуулиуд лекц, семинарт сургалтын материалыг мультимедиа илтгэл хэлбэрээр танилцуулахыг шаардаж байгаа бөгөөд энэ нь сонсголын бэрхшээлтэй, түүний дотор аман мэдээллийг зөвхөн чихээр хүлээн авахад хэцүү байдаг оюутнуудад боломжийг олгодог. Дээд боловсролын байгууллагууд тусгай хэрэгцээт суралцагсдад зориулсан сурах бичиг, гарын авлага боловсруулж, байршуулахад анхаарах, боловсролын орчин, боловсролын хүртээмжийг бүрдүүлэх нь машинд чухал хүчин зүйл болоод байна.

Тусгай хэрэгцээт боловсролд хамрагдаж буй суралцагчдад хичээл зааж буй багшид тавигдах нийтлэг шаардлагыг танилцуулбал:

1) Хүний хөгжил, хувь хүний онцлог ялгаатай байдлыг мэддэг.

Суралцагчдынхаа мэдлэг чадвар, хандлага, сонирхол хүсэл, амьдралын үнэт зүйлс, хөгжил төлөвшлийг гярхай ажиглан мэдэж тэдгээрийг улам баяжуулан хөгжүүлэх чадвартай байх

2) Соёл уламжлал, хэл сэтгэхүй, гарал үүслийн ялгаа суралцагчдынхаа сургалтын орчин дахь эрх тэгш оролцоо, бие биенээ хүндэтгэсэн шударга, ёс зүйтэй харилцаа ээлтэй орчинг бий болгож чаддаг суралцагч нэг бүрийн сургалтын үйлчилгээ авч чадаж байгаад хяналт тавьж хэрэгжүүлэх

3) Тухайн хэрэгцээт суралцагчийн ар гэр, асран хамгаалагч нартай хамтран ажиллаж суралцагчийн онцлог байдлыг ойлгуулж, туслан дэмжих

4) Шалгалт, үнэлгээ төстийн материалыг хөгжлийн онцлог хэрэгцээнд нийцүүлэн олон хувилбартай боловсруулан гаргах чадвартай, хүсэлтэй байх

5) Багш нь тохиромжтой харилцааны хэрэгсэлийг сонгон идэвхитэй харилцах боломж нөхцөлийг бүрдүүлэн нээлттэй элгэмсэг найрсаг харилцах

6) Суралцагч оюутнуудаа хамтран ажиллах чадвар дадал эзэмшүүлэн хөгжүүлэх нарийн мэдрэмжтэй байх

7) Тусгай сургалтын хөтөлбөрт нийцүүлэн тохиромжтой заах арга зүйг сонгон авч бие хүнийг хөгжүүлэн төлөвшүүлэх чадвартай байх

8) Нийгмийн аливаа хүндрэл бэрхшээлийг даван туулах, сэтгэл зүйн бэлтгэлтэй, бусдаас хараат бус чанартай хүртээмжтэй сургалтын орчинг бүрдүүлэхэд санаачлагатай ажиллах

9) Мэдээлэл техник технологийн хөгжил дэвшлийг соргоор мэдэрч сургалт хүмүүжлийн ажлыг дэмжин сайжруулагч байх

10) Тусгай боловсролын үйлчилгээ шаардлагатай суралцагчийн талаарх хууль эрх зүй, нийгэм сэтгэл зүйн мэдлэг ойлголттой байх

Тусгай хэрэгцээт боловсролд хамрагдаж буй суралцагчдыг хөгжүүлэн төлөвшүүлэхэд сургуулийн зүгээс зөвхөн багш ажилтнууд төдийгүй тэдний гэр бүл, асран хамгаалагчдад идэвхитэй нөлөөлөн тэдний оролцоог нэмэгдүүлэн хамтран ажиллах нь сайн туршлага болсоор байна.

Хүн бүхэн зорилго тэмүүлэлтэй, авъяас чадвартай байдаг. Түүнчлэн хүнийг агуулж буй орчин нь ямарваа нэгэн нөөц боломж, дэмжин туслах харилцаа холбоог өөртөө багтаасан байдаг. (Д.Одгэрэл Б. М., 2017)

- Сул тал, хүндрэл бэрхшээлээс илүү давуу тал, нөөц боломжийг эрэлхийлэх

- Бэрхшээл саадыг тоочихоос илүү боломжит олон хувилбарыг гаргах

- Үйлчлүүлэгчийн эмгэг, доголдолтой байдлыг тодорхойлохоос илүү сайн тал, авъяас чадварыг нээн хөгжүүлэхэд ач холбогдол өгөх бодит орчинг бүрдүүлэх боломжийг олгодог.

Дээд боловсролын байгууллагууд оюутны хөгжил болон оюутны халамжийн талаар хүний нөөцийн болоод дэд бүтцийн (чадавхийн) нөөц бололцоог ихээхэн хэмжээгээр нэмэгдүүлэх шаардлагатай хэрэгцээтэй байдаг. Оюутан суралцагчдыг хүсэл мөрөөдлөө биелүүлэх, өдөөж урамшуулах, сэтгэл хангалуун байлгах олон янзын арга замууд бий. Хэдийгээр дээрх чиглэлийн дэмжлэг нь өртөг өндөртэй ч оюутнуудад суралцах таатай бололцоог хангадаг. Шаардагдах хөрөнгийг сургуулийн төсөвт суулгах нь сургалтын орчинг бүрдүүлэхэд чиглэгдэнэ. (IDEA, 2004).

Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч болон тэдний гэр бүлийн сэтгэл зүй оюуны дархлааг дэмжих, өөртөө итгэх итгэл, амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн оношилогоонд суурилсан, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээ, сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх төвтэй байх хэрэгцээ шаардлагатай байдаг. (Liefect, 2003) Манай сургуульд сэтгэл зүйн зөвлөгөө өгдөг төв үйл ажиллагаа явуулдаг үүнийг улам

бүр зорилтод үйлчлүүлэгч руу чиглүүлэх хэрэгцээтэй байгаа билээ.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Тусгай хэрэгцээт боловсролын үйлчилгээг төлөвлөхдөө тун хариуцлагатай, уян хатан байдлаар хандах ёстой. Тусгай хэрэгцээт суралцагч нь бүх төрлийн үйлчилгээг байршил, давтамж, хүний нөөц, үргэлжлэх хугацаа зэргээс үл хамаарч саадгүй хүлээн авч байх нь чухал ач холбогдолтой юм.

- Бусад суралцагчдын адил өөрийн зохих мэдлэгийг бүтээхийн тулд суралцах явцыг өөрт нь ойлгомжтой байдлаар тохируулга хийн дэс дарааг тодорхой болгож, хуваарийн дагуу мөрдүүлэх журамтай байх
- Хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар хөгжих боломжийг бүрдүүлж өгөх
- Өөртөө үйлчлэх энгийн аргад суралцахад дэмжлэг үзүүлэх
- Зааж байгаа хичээлтэйгээ холбож ялгаатай байдлын даалгавар хийж өгөх
- Суралцагч оюутны чадах зүйлд тулгуурлан хөгжүүлэх
- Итгэл өгч урамшуулах
- Завсарлагаагаар эсвэл хичээлийн дараа ярих цаг гаргаж, орчныг нь бүрдүүлж өгөх
- Багш хамтран түүнтэй өөрийгөө танилцуулах болон үзэл

бодол, санаагаа илэрхийлэх цаг гарган ярилцахад нь дэмжих

- Харааны бэрхшээлтэй суралцагчдад зориулсан сурах бичгийг брайл хэлбэрт шилжүүлэн хэвлэх, зарим сурах бичгийг Дейзи буюу сонсох хэлбэрт шилжүүлэх, харааны болон сонсголын бэрхшээлтэй сурагчдад нэн тэргүүн шаардлагатай техник хэрэгсэл, төхөөрөмжөөр хангах үйл ажиллагааг эхлүүлэн дэмжих
- Дохионы хэлний багш нар шинжлэх ухааны хэллэгийг хэрхэн яаж дохих вэ гэдгийг хамтран боловсруулах хэрэглэх
- Засгийн газрын 2020 оны “Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 208 дугаар тогтоолоор ердийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багшид үндсэн цалингийн 10 хувийн нэмэгдэл хөлс олгохоор шийдвэрлэсэн үүний адил их, дээд сургуулийн багш нарт дэмжлэг урамшуулал өгөх
- Хөгжлийн бэрхшээлийн талаар нийт ажилтнууд нь сургалтанд хамрагдсан байх, сургалтыг боловсруулах, явуулахдаа үйлчилгээг хүртэгчдийг хамруулж сургалтыг зохион байгуулах
- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн эрхийг нь, мөн гомдол гаргах механизмыг

мэдээлэх урсгалыг нэмэгдүүлэх, эргэх холбоотой байх

- Хөгжлийн бэрхшээлтэй оюутан, ажилтныг элсэн орох, оролцоход тулгарах саад бэрхшээлийг арилгахад нь илүүтэй анхаарах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, оюутан залууст боловсрол эзэмших сурах олон төрлийн аргачлалыг хүлээн зөвшөөрөх
- Их, дээд сургуулийн багш нар, тусгай хэрэгцээт боловсролын багш нар, дохионы хэлмэрч-орчуулагч, сэтгэл зүйч, IT-ийн инженерүүдийн хамтарсан багаар цахим контент, цахим болон теле хичээлүүдийг хөгжүүлэх
- Сургалтад ашиглагдаж буй ном, сурах бичгийг хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын онцлог хэрэгцээнд нийцүүлэн хүртээмжтэй хэлбэрээр түгээх /аудио, видео, DVD, брайл, дохионы хэлээр бэлтгэсэн контент, хичээлүүд, дүрс зурган өгүүлэмжтэй цахим сургалтын талбарыг уламжлалт сургалттай хослуулан хөгжүүлэх/ хамгийн сайн дэмжлэг болно.

ДҮГНЭЛТ

Манай улсад хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын боловсролын тухай бие даасан хууль байхгүйгээс гадна хөгжлийн бэрхшээлтэй болон тусгай хэрэгцээт боловсролын үйлчилгээ

шаардлагатай суралцагчийн хэрэгцээний талаар нарийвчлан тусгасан зүйл заалтууд Монгол улсын Боловсролын болон нийгмийн хамгаалал, халамжийн хуулинд аль алинд нь тусгагдаагүй байна.

Тиймээс тусгай хэрэгцээт боловсролын мэргэжлийн ямар

бэрхшээлтэй суралцагчдад ямар тусгай хэрэгцээ шаардлагатай болохыг олон улсын практик, баримт, судалгаа, стандарт, гэрээ, конвенциос судлан хэрэглэн хэвшүүлэх шаардлагатай байна. (ХНХЯ, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх арга зүй, 2019)

НОМ ЗҮЙ

1. НҮБ, "Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөгжлийн онцлог бүхий суралцагчдыг эрхийн тухай конвенц," UNDP, р. 24.2, 2011 дэмжих онол, арга зүй," 2018.
2. УИХ, "Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль," УИХ, р. 14.1.3, 2016.
3. АНУ, "АНУ-ын хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсролын тухай хууль," АНУ, 2004.
4. БШУЯ, "БШУЯ," <https://www.meds.gov.mn/>, 2022.
5. MNS, "ISO21001:2021," Стандартчилал хэмжил зүйн газар, УБ, 2021.
6. W. B. World Health Organization, "Word report on disability," World Health Organization, 2011.
7. ХНХЯ, "Нийгмийн халамжийн тухай хууль," Эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл, р. 49, 2008.
8. Д.Одгэрэл, "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэдэй ажиллах мэргэжилтнүүдэд зориулсан гарын авлага," Боловсрол судлал, 2009.
9. Д.Одгэрэл, "Тусгай боловсрол хөгжлийн онцлог бүхий суралцагчдыг хамруулах боловсрол," 2017.
10. Б. М. Д.Одгэрэл, "Тэгш хамруулах боловсрол," 2017.
11. IDEA, "Individuals with Disabilities Education Act," IDEA, 2004.
12. F. Liefect, "Working with students who are blind or visually impaired, including those with additional disabilities," Collaborative assessment, 2003.
13. ХНХЯ, "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх арга зүй," 2019.
14. WHOQOL, "The Word Health Organization quality of life assessment," Social Science & Medicine, pp. 1403-1409, 1995.
15. Б.Болор, "Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэм хамт олонд түшиглэн сэргээн засах нь," Боловсрол судлал, 2014.